

2014 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Ховд хот

2014 онд улс, орон нутгийн эдийн засгийн өсөлт саармагжиж, хөрөнгө оруулалт огцом буурч, улсын төсвийн орлого тасарсан хэдий ч Ховд аймгийн хувьд Монгол улсын Засгийн газар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ард иргэд, хувийн хэвшлийнхэнтэйгээ хамтран хичээн зүтгэсний үр дүнд чамгүй ололт, амжилттай жил боллоо.

Монгол улсын хөгжлийн тулгуур баримт бичгүүдтэй уялдуулан “Ховд аймгийн хөгжлийн стратеги” (2015-2025 он), “Ховд аймгийн хөрөнгө оруулалтын талаар баримтлах бодлого”, “Ховд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” зэрэг бодлогын чухал баримт бичгүүдийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлууллаа.

2014 онд аймаг, бүс, улс, олон улсын хэмжээнд Монголын төр, шашины нэрт зүтгэлтэн, Галдан бошигт хааны мэндэлсний 370 жилийн ой, Монгол улсын Ерөнхий сайдын ивээл дор “Баруун бүсэд хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалт”, “Галдан бошигт судлал”-ын олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, Хөөмийн олон улсын III наадам, “Ховд-2014” бага олимп, “Мөнгөлөг шагшуурга” цас мөсний баяр зэрэг томоохон арга хэмжээг азохион байгууллаа.

Анх удаа Ховд аймагт зохион байгуулсан “Баруун бүсэд хөрөнгө оруулагчдын олон улсын чуулга уулзалтын үеэр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад 100 гаруй төслийг танилцуулж, 300.0 гаруй тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий хамтран ажиллах 13 санамж бичиг, хөрөнгө оруулалтын нэг гэрээнд аймгийн Засаг дарга гарын үсэг зурав.

Нэг: Төрийн байгуулалт, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль эрхзүйн бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлд:

Төрийн байгуулалтын талаар:

Аймгийн ИТХ-ын шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд төр захиргааны байгууллагын удирдлага, албан хаагчдын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, ил тод, шуурхай, хариуцлагатай байдлыг хангаж, нэг цонхны үйлчилгээг өргөтгөн иргэд, олон нийтийн оролцоог хангасан сайн засаглалыг бэхжүүлэн, иргэдэд хүртээмжтэй үйлчилдэг нийтийн албыг бий болгохын төлөө нилээд ажлыг санаачлан хийлээ.

Аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн, боловсон хүчний бодлогыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, тэднийг сургах, төрийн албаны сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авч цаг тухайд нь шийдвэрлэх, хууль тогтоомжийн биелэлтийг тооцох, гадаад харилцааг өргөжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллав.

Ардчилал, ил тод байдлын хүрээнд аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүдэд Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо, Ахмадын хороо, Залуучуудын холбооны төлөөллийг оролцуулж, шийдвэр гаргахад иргэд, иргэний нийгмийн оролцоо, хяналтыг сайжруулав.

2014 оны нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлаар, аймгийн Засаг даргын Тамгын газрын жил, улирлын төлөвлөгөөг Тамгын газрын даргаар тус тус батлуулан биелэлтэд нь хяналт тавьж ажиллав.

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр гаргаж биелэлтэд нь хяналт тавьж ажилласан бөгөөд Монгол улсын Засгийн Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлж байлаа. Засаг даргын зөвлөлийн хурал, шуурхай зөвлөгөөн, бусад хурал зөвлөгөөн, иргэд хөдөлмөрчдийг хүлээн авч уулзах, тэдний санал бодол, хүсэлтийг сонсох цаг өдрийг товлон, уулзалтын бэлтгэлийг сайтар хангаж зохион байгуулса Засаг даргын тоот албан даалгавруудыг биелүүлэхэд бүх шатны байгууллагын идэвхи, оролцоог сайжруулсанаар төр, захиргааны байгууллагын ажлын уялдаа, холбоо сайжирлаа.

2014 онд амжилт бүтээлээрээ шалгарсан салбар салбарын 9 алдартан, аймгийн сайн малчин, тэргүүний тариаланчдын тодорхойлолтыг холбогдох албан тушаалтанд шилжүүлэн, дүгнэх журмын дагуу шалгуур үзүүлэлтүүдээр байр эзэлүүлэн, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодруулав.

Ховд аймгийн Алтай сумын Алтангадас багийн иргэн Ч.Сонинпил, Чандмань сумын иргэн Д.Төрбат нар улсын сайн малчин, Буянт сумын иргэн Г.Боролхаан нар тэргүүний тариаланчаар шалгарч сайхан амжилт гаргалаа.

Сум, байгууллагуудад ёс зүйн хороо байгуулж үйл ажиллагааны талаар үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгч ажиллалаа. Аймгийн 17 сум, аймгийн төвийн сургууль, цэцэрлэг, өрхийн ЭМТөвүүд, аймгийн Засаг даргаын Тамгын газар, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, Шүүх, Цагдаа, Шүүхийн шинжилгээний алба зэрэг газруудад нийт 35 ёс зүйн хороо ажиллалаа.

Аймгийн шагналын журмын дагуу, тэмдэглэлт өдрүүд, сум, байгууллагуудын ойгоор 2014 онд орон нутгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үйлсэд өндөр амжилт гаргасаж, хариуцсан ажлаа нэр төртэй биелүүлсэн, иргэдийн хөдөлмөр, зүтгэлийг үнэлж аймгийн Засаг даргын Жуух бичгээр 32, Засаг даргын өргөмжлөлөөр 75, аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 588 хүнийг шагнаж урамшууллаа.

Төрийн албаны аймгийн салбар зөвлөлийн талаар:

Төрийн албаны аймгийн салбар зөвлөлийн 2014-2016 он хүртэлх стратеги төлөвлөгөөг батлуулан, гүйцэтгэлийн удирдлагын талаар төрийн удирдлагын хэвийн үйл ажиллагааг хангах, шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх, төрийн албыг хуульд нийцсэн, шаардлага хангасан, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэхэд анхаарч ажиллав.

Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхийн тулд гишүүдийн ажил, үүргийн хуваарийг баталж, төрийн албан хаагчдын хэрэгцээ шаардлагын дагуу 47 албан хаагчийг урт, богино хугацаагаар ХБНГУ, Япон, АНУ, Швейцарь, Итали, Вьетнам, Сингапур, БНХАУ, ОХУ зэрэг орнуудад болон дотоодын сургалтанд хамруулан, туршлага судлуулж, төрийн удирдлагаар

менежер бэлтгэх, төрийн удирдлага болон мэргэжлийн зэрэгтэй албан хаагчдыг бэлтгэх, дахин мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулан ур чадварыг нь дээшлүүлэв. сургалтанд хамрууллаа.

Төрийн албан хаагчдыг сургалтанд хамруулахдаа тэдний ажлын байранд тавигдах шаардлага, ур чадвар нь ямар түвшинд байгаад үнэлгээ өгч, саналыг нь харгалзан, үр дүнгийн гэрээнд нь тусгаж, сургалтын байгууллагуудтай гэрээ байгуулан ажлын байранд нь сургаж, мэргэжил дээшлүүлэх ажлыг зохион байгууллаа. “Багийн амжилт-миний ажлаас” сэдэвт сургалтыг сумдын Иргэдийн нийтийн хурлын дарга, Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагуудын дарга, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдэд тусгайлан зохион байгуулсан нь баг, хамт олны ажлын уялдаа, холбоог сайжруулахад нилээд үр өгөөжтэй боллоо.

Салбар зөвлөлийн хурлыг 12 удаа зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн албажуулж, хуралдааны шийдвэрийн үр дүнг тооцон ажиллав. Төрийн албаны тухай хууль, журам заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар давхардсан тоогоор 122 байгууллагад албан бичгээр зөвлөмж, хүргүүлэн ажилласны үр дүнд хууль журмын хэрэгжилт өмнөх жилүүдээс сайжирсан гэж үзэж болно.

2014 онд 12 байгууллага, 17 сумын эрх бүхий албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч, Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд аймгийн төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хуулийн хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүллээ.

Төрийн жинхэнэ албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг 2 удаа цахим хэлбэрээр зохион байгууллаа. 3 дугаар сард зохион байгуулсан шалгалтад 34 ажлын байрны сул орон тоонд 260 иргэн бүртгүүлэн мэргэшлийн шалгалтад орж 11 дүгээр сард зохион байгуулсан шалгалтад 56 ажлын байрны сул орон тоонд 332 иргэн, нийт 592 иргэн бүртгүүлэн мэргэшлийн шалгалтад орж 91 иргэн тэнцэн, Төрийн албаны зөвлөлийн 151 дүгээр тогтоолоор төрийн албанд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэв.

Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 402 дугаар тогтоол, Ховд аймгийн салбар зөвлөлийн 10 дугаар тогтоолоор төрийн албанд анх орж шалгалтад тэнцсэн 47 иргэнээс 18 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэн дүгнэлт гаргаж томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэв.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн болон Ховд аймгийн албан ёсны цахим хуудсууд, орон нутгийн “Ховдын толь” “Ховдын мэдээ” сонин, “Цаст”, “Эко”, “Ховд” телевизүүд, 17 сумдад албан бичгээр 21 хоногийн өмнө шалгалтыг зарыг хүргүүлж, ард иргэдэд нээлттэй мэдээлж байсан учраас энэ талаар ямар нэг өргөдөл гомдол ирээгүй.

Тайлангийн хугацаанд төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөд 147 иргэн, удирдах ажилтны нөөцөд 95 иргэн бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс анх

орох иргэний нөөцөөс 60 иргэн, удирдах ажилтны нөөцөөс 43 иргэн ажилд томилогдож, үүнээс 21 иргэн бусад салбар зөвлөл болон байгууллагуудад дүгнэлтээр болон нөөцөөс шилжүүлэн бүртгүүлж, нөөцийн сангийн мэдээллээр үйлчлүүлсэн болно. Салбар зөвлөлд 11 гомдол ирж салбар зөвлөлийн хурлаар шийдвэрлэн, хариуг албан бичгээр хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд 62 төрийн албан хаагчтай холбоотой ёс зүйн зөрчлийн мэдээ хүлээн авч дүгнэлт хийхэд 49 нь анх удаа, 13 нь давтан зөрчил гаргасан тул Төрийн албаны тухай хуулийн 26.1.1 дэхь заалтын дагуу 7 албан хаагч, 26.1.2 дахь заалтын дагуу 36 албан хаагч, 26.1.3 дахь заалтын дагуу 2 албан хаагчдад сахилгын шийтгэл хүлээлгэв.

Засгийн газрын 1995 оны 73 дугаар тогтоолын дагуу шаардлагад нийцсэн, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 албан хаагч, 16 байгууллагын 53 төрийн захиргааны албан хаагчдад зэрэг, дэвийн нэмэгдэл олгож, Ерөнхий сайдын Захирамжаар аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад Эрхэлсэн түшмэлийн дөтгөөр зэргийг олгов.

Тус тогтоолын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын 8 төрийн жинхэнэ албан хаагчид журмын дагуу зэрэг дэв олгож, 82 албан хаагчид, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг нэг, ажил хавсран гүйцэтгэсэн дөрөв, нууцын нэмэгдэл гурав, ур чадварын нэмэгдлийг долоон албан хаагчид тус тус олголоо.

Холбогдох журам, зааврын дагуу Засаг даргын Тамгын газраас өндөр насны тэтгэвэрт гарсан гурван төрийн албан хаагчид 6-36 сарын тэтгэмж, байгууллагын дотоод журмаар нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгов. Дотоод журмын дагуу байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан ажилтнууд болон өрхийн тэргүүн, өрх толгойлсон эмэгтэйчүүдэд түлээ, нүүрсний хөнгөлөлт, 10 төрийн албан хаагчид ур чадварын болон бусад нэмэгдэл олгов.

Аймгийн Аудитын газрын дарга Л.Галбадрах, Стандартлал хэмжил зүйн газрын мэргэжилтэн Д.Цогтхүү, Мянгад сумын иргэн Д.Энхтуяа нар “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдэг хүртлээ.

Монгол улсын Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 134 дүгээр тогтоолын төрийн жинхэнэ албан хаагчидтай жил бүр “Үр дүнгийн гэрээ” байгуулж ажиллана гэсэн заалтын дагуу Засаг даргын Тамгын газрын нийт 33 албан хаагчтай “Үр дүнгийн гэрээ” байгуулан дүгнэхэд А үнэлгээтэй 19, В үнэлгээтэй 13, С үнэлгээтэйгээр 1 албан хаагч гэрээгээ дүгнүүлэв.

Үр дүнгийн гэрээний хэрэгжилт хангалтгүй, дутагдалтай үнэлгээ авсан удирдах ажилтан болон, төрийн албан хаагчдад тус тогтоолд заасны дагуу албан тушаал бууруулах, албан тушаалын цалинг бууруулах, сахилгын шийтгэл ногдуулах, төрийн албанаас халах зэрэг арга хэмжээ авч, Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар 3 төрийн албан хаагчид сануулах, 1 албан хаагчид үндсэн цаоингийн тодорхой хувийг бууруулах арга хэмжээ авлаа.

Аймгийн www.khovd.gov.mn цахим хуудсанд Төрийн албаны салбар зөвлөл гэсэн тусгай цэс нээж, зөвлөлийн үйл ажиллагаа, тайлан, мэдээ, судалгаа, авсан төрийн албан хаагчдын мэдээлэл, зэрэг дэв, төрийн жинхэнэ албанд анх орох

иргэний мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалт, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ зэрэг салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллүүдийг байршуулан цаг тухайд нь шинэчилж ажиллав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.2 дугаар заалтын дагуу “Нээлттэй хаалганы өдөр” буюу “Иргэдийн өдөр”-ийг зохион байгуулах төлөвлөгөөг сум, байгууллагуудаас хүлээн авч, аймгийн хэмжээний нэгдсэн график гарган, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулж, биелэлтэнд хяналт тавьж, сум бүрд “Иргэний танхим” байгуулан, төрийн байгууллага, иргэнийг холбосон олон нийттэй харилцах арга хэмжээг тогтмолжуулан, сар бүрийн 1 өдрийг “Иргэдийн өдөр” болгон зохион байгууллаа.

Сум, байгууллагуудын зохион байгуулсан “Нээлттэй хаалганы өдөр”-ийн хагас жилийн тайланд Хяналт, шинжилгээ, үнэлгээний тасаг үнэлгээ хийж, зөвлөмж ирүүлснийг сум, байгууллагуудад хүргүүлэв.

Сум бүр Иргэний танхимыг байнгын ажиллагаатай болгож “Шууд ардчилал-иргэдийн оролцоо” хэлбэрийг байнга хэрэгжүүлэх арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, сумдын цахим хуудсаар төрийн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй мэдээлж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолын хавсралтын дагуу сум, байгууллагаас зохион байгуулсан “Нээлттэй хаалга”-ны өдрөөр 7 байгууллага, 2 сум нийт 56 нэр төрлийн асуудлаар иргэдийн саналыг хүлээн авч шийдвэрлэлээ.

Зарим байгууллагын “Нээлттэй хаалга”-ны өдрөөр зохион байгуулсан онцгой арга хэмжээний талаар товч дурдвал:

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар 2014 оны төлөвлөгөөний дагуу газар олгох төлөвлөгөөг 12 багийн нээлттэй хаалганы өдрөөр танилцуулж, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль, тогтоомжийг иргэдэд сурталчилж, зөвлөмж гарын авлагаар хангав.

Хөдөлмөрийн хэлтэс “Ажилтай орлоготой Ховд хүн” хөдөлмөрийн яармаг зохион байгуулан, иргэн, 25 ажил олгогч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 70 гаруй ажлын байрыг нээлттэй зарлан зуучилж, ажил идэвхитэй хайгч иргэдийг бүртгэн, зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүллээ.

Нийгмийн даатгалын хэлтэс нийгмийн даатгалд хамруулах аяны явцад 53 иргэнийг сайн дурын, 34 иргэнийг эрүүл мэндийн даатгалд тус тус хамруулан, 63 иргэний нийгмийн даатгалын дэвтрийг баталгаажууллаа.

Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны алба хаагчид, тэдний гэр бүл нийт 400 гаруй иргэдийг оролцуулан сургалт хийж, хүүхэд хамгааллын бодлогыг үр өгөөжтэй хэрэгжүүлэх талаар судалгаа авч нэгтгэн дүгнэж байгууллагын удирдлагад хүргүүлсэн нь ихээхэн дүнтэй ажил болж, Баруун бүсийн “Их хурд-2014” даншиг наадмын хурдан морь унах 324 хүүхдүүдийг шаардлага хангасан хувцастай болгож, эмчийн үзлэгт оруулан, 100 хувь даатгалд хамрууллаа.

Цагдаагийн газар байгууллагынхаа үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах, гэмт хэрэгтэй тэмцэх нийгмийн хэв журам хамгаалах ажилд иргэд, олон нийтийн оролцоо, тэдний дэмжлэг туслалцааг өргөжүүлэх, хамтран ажиллах зорилгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 1050 ш, 8 төрлийн сэрэмжлүүлэгийг тарааж, амаар болон бичгээр 21 гомдол хүлээн авч шалган хуулийн дагуу шийдвэрлэжээ.

Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс 6 аж ахуйн нэгжийн 2 нэр төрлийн 20 бүтээгдэхүүнд тохирлын үнэлгээ хийж, эрхийн хугацаа дууссан 1 аж ахуйн нэгжийн 5 нэр төрлийн бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ хэрэглэх эрх олгосон.

Хар нуур Ховд голын сав газрын захиргаанаас “Ус чандмань эрдэнэ” хүний амьдралын үнэт хэрэглээ юугаар ч орлуулшгүй байгалийн баялаг” уриан дор Буянт голын цэвэрлэгээний ажлыг орон нутгийн Эко ТВ-тэй хамтран, 47 байгууллага аж ахуйн нэгжийг хамруулан зохион байгууллаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж, 173 иргэнтэй уулзаж байгууллагын үйл ажиллагааг сурталчилан танилцуулж санал хүсэлтийг нь авч, тус хорих ангид ял эдэлж байгаа ялтнууд болон тэдний ар гэртэй өдөр бүр нээлттэй уулзалт зохион байгуулж, давхардсан тоогоор 231 ялтан, ар гэрийн 1119 иргэний санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлэн зөвлөгөө өгч, байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчилсан.

Хавдар судлалын үндэсний төвтэй хамтран БОЭТөвөөс “Хавдрын эсрэг үндэсний аян 2014” арга хэмжээ зохион байгуулж нийт 5500 орчим иргэнийг үзлэг оношлогоонд өргөнөөр хамруулан аймаг, дүүрэг, сум, өрхийн 3150 орчим эмч мэргэжилтэнийг сургалтанд хамруулан, 1300 гаруй сайн дурын идэвхтнийг бэлтгэн дадлагажуулав.

Сум, байгууллага, дотоод ажлын талаар:

Засаг даргын Тамгын газраас аймгийн хэмжээнд нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй, ил тод нээлттэй, шуурхай болгох, хариуцлагыг дээшлүүлэх, төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага чадавхийг өндөржүүлж, бодлогын зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хөдөөгийн багийн төвүүдийг тохижуулах, шинээр барьж байгуулах, техник хэрэгслээр хангах ажлуудыг зохион байгуулж ажиллав.

Аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2014 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад орон нутгийн давуу тал, нөөц бололцоондоо тулгуурлан бүх шатанд ажилласны үр дүнд аймгийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт болох ДНБ 268 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оныхоос 24,6 хувиар өсч, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 3,3 сая төгрөг боллоо.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Засгийн газрын 2013 оны тогтоолоор баталсан аргачлалын дагуу тооцож үзэхэд нийт 454 заалтаас хугацаа болоогүй-46, хэрэгжээгүй-4, 10 хувийн хэрэгжилттэй-15, 30 хувьтай-42, 50 хувьтай-182, 70 хувьтай-86, 90 хувьтай-13, 100 хувь хэрэгжсэн-66 заалт, дундажаар 58,9 хувийн биелэлттэй гарсан бөгөөд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн

хэрэгжилтийн явцыг хагас, бүтэн жилээр тооцон, Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж “Хангалттай” үнэлгээ авлаа.

Аймгийн Засаг даргын зөвлөл 21 удаа хуралдаж, 78 асуудал хэлэлцэн, 37 асуудлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж, бусад шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хурлын тэмдэглэлээр хүргүүлсний хэрэгжилтийг тооцож үзэхэд 95,8 хувьтай байна.

Хариуцлагатай засаглал, төрийн худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод тогтолцоог бэхжүүлэх, хүүхдийн эрх, эрүүл мэнд, усан хангамж ариун цэврийн байгууламжийг сайжруулах зэрэг 15 төслийг олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн оролцоотойгоор хэрэгжүүлсэний үр дүнд орон нутгийн хөгжил, ард иргэдийн амьдралд 5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын болон сум, байгууллагын цаг үеийн ажлын товч мэдээллийг сар бүр нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, аймгийн www.khovd.gov.mn цахим хуудсанд цаг тухайд нь байрлуулж, олон нийтэд мэдээлж ажиллалаа.

Аймгийн удирдах ажилтны шуурхай зөвөлгөөнийг 12 удаа зохион байгуулж, зөвөлгөөнөөс гарсан 72 үүрэг, чиглэлийг байгууллагуудад тэмдэглэлээр хүргүүлэн ажилласны биелэлт 98 хувьтай байна.

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчийн сумдын Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нартай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ байгуулж, сумын Засаг даргын баримтлах зарчмыг баталж, сум, багийн хөгжлийг шинэ түвшинд гаргах, хөдөө орон нутгийн иргэдийг амьдрал ахуй, орчинг сайжруулах чиглэлээр тодорхой үүрэг, чиглэлүүдийг өгч, тухай бүр нь хяналт тавьж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний албан байгууллагуудын төсвийн шууд захирагчид, сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нартай Үр дүнгийн гэрээ байгуулж, төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй, түргэн шуурхай болгоход анхаарч ажилласны үр дүнд ажлын үр өгөөж мэдэгдэхүйц сайжирлаа.

Сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дарга нартай 2014 онд ажиллах үр дүнгийн гэрээг Засгийн газрын 2012 оны 134 дүгээр тогтоолын хавсралтын дагуу хугацаанд нь байгуулан, гэрээний илтгэх хуудсыг хүлээн авч, 12 дугаар сард багтаан дүгнэж, 2015 оны гэрээг Төсвийн тухай Монгол улсын хуулийн дагуу хугацаанд нь байгуулж дууслаа.

2014 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дуут сумын Цагаанбургас багийн төв барих ажлыг 100,0 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5 багийн төв барих, 4 багийн төвийн барилга засварлах ажлыг 404,5 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн бөгөөд сумдаас ирүүлсэн саналын дагуу Үенч, Чандмань, Дарви, Ховд, Эрдэнэбүрэн, Мөст, Алтай сумын Засаг даргын Тамгын

газрын автомашин худалдан авах зардалд 144,0 сая төгрөг, хөдөөгийн 62 багийн дарга нарт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 39,7 сая төгрөг, багийн Засаг дарга нарыг 42,6 сая төгрөгөөр унаажуулан мотоциклтой болгосны үр дүнд орон нутаг, багт төрийн үйлчилгээг иргэдэд түргэн, шуурхай, ил тод, хүртээмжтэй хүргэх нөхцөл нэмэгдлээ.

Сумдын Засаг дарга нартай байгуулсан аймгийн Засаг даргын гэрээнд сумдад ахуйн үйлчилгээ, бизнес инкубатор төв байгуулах зорилтыг тусган хяналт тавьж ажилласнаар Мөст сум "Туяа" нэгдлийн хуучин барилгыг 30,0 сая төгрөгөөр ахуйн үйлчилгээний төв болгон ашиглахаар засварлаж, Буянт суманд 99 м² бүхий 6 өрөөтэй, Эрдэнэбүрэн суманд 108 м² 3 өрөө бүхий ахуйн үйлчилгээ, бизнес инкубатор төвийг ОНХС-гийн хөрөнгөөр барилаа.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн хэрэгжилтийг ард иргэдэд сурталчлах зорилгоор орон нутгийн телевизүүдтэй гэрээ байгуулан, батлагдсан хуваарийн дагуу "Төрийн мэдээллийн цаг" нэвтрүүлэг 2700 минут, "Бүтээн байгуулалтын цаг" нэвтрүүлэг 3000 минутын мэдээллийг иргэдэд хүргэлээ.

2014 онд нийтээр тэмдэглэх ой, тэмдэглэлт өдөр, спорт урлагийн арга хэмжээ, сургалт зөвлөгөөний нэгдсэн төлөвлөгөөг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулан хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллав. Түүхт ой, томоохон арга хэмжээний хүрээнд бүтээлч санаачлага өрнүүлэн, олон төрлийн ажил зохион байгуулан иргэд, олон нийтийг татан оролцууллаа.

2014-2015 оны хичээлийн жилд Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуульд тав, нийгмийн удирдлагын сургуульд гурав, магистрын ангид нэг төрийн албан хаагч амжилттай элсэн суралцаж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд жендэрийн салбар хороо дараах зүйлүүдийг санаачлан ажиллалаа. "Гэр бүлийн цаг" нэвтрүүлгийг тогтмолжуулан хуваарийн дагуу иргэдэд хүргэж хэвшлээ. Дуут, Дөргөн сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /2/, Алтай, Зэрэг сумдын Засаг дарга /2/, Алтай, Дарви сумдын Засаг даргын орлогч /2/, Зэрэг, Мөст, Мөнххайрхан, Жаргалант, Мянгад сумдын Засаг даргын Тамгын газрын дарга /5/, баруун бүсийн зөвлөлийн дарга /1/, аймгийн Засаг даргын Тамгын газрын ТЗУХ-ийн дарга /1/, Хяналт, шинжилгээ, үнэлгээний -ийн дарга /1/, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хэлтсийн дарга /1/, аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч 4, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын дарга /8/, сургуулийн өмнөх боловсрол, цэцэрлэгүүдийн эрхлэгч нар /37-37/, ерөнхий боловсролын сургуулийн захирлууд /24-өөс 13/ нийт 77 эмэгтэй шийдвэр гаргах түвшинд ажиллаж байна.

Эрэлт хүсэлт, өргөдөл, гомдлыг барагдуулах талаар:

"Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль, "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны

67 дугаар тогтоол, Засаг даргын 2001 оны 127 дугаар захирамжаар баталсан “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу аймгийн аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт болон сум, байгууллагуудад ирсэн иргэдийн өргөдөл гомдлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хүлээн авч, шийдвэрлэж, төрийн бодлого шийдвэрийг иргэддээ нээлттэй ил тод хүртээмжтэй хүргэхэд ажлаа чиглүүлэн, аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлыг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Монгол улсын Засгийн газрын 2014 оны 9 дүгээр хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүргийн хэрэгжилтэнд хяналт тавьж, сум, байгууллагаас ирүүлэх өргөдөл гомдлын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргах, тэдгээрт хяналт шинжилгээ хийх зорилгоор сум, байгууллагын өргөдөл гомдол хариуцагчтай хамтран хяналт тавьж ажиллав.

Тэмдэглэлээр өгөгдсөн үүргийн дагуу сум, байгууллагаас ирүүлэх өргөдөл гомдлын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж, тэдгээрт хяналт шинжилгээ хийлгэх зорилгоор аймгийн төвийн төрийн байгууллагын өргөдөл гомдлын асуудал хариуцсан 42 төрийн албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай”, сумдын Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч болон өргөдөл гомдлын асуудал хариуцсан 23 төрийн албан хаагчдад “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх тухай”, багийн Засаг дарга нарт “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх болон албан хэрэг хөтлөлтийн талаар” сэдэвт сургалтуудыг 3 үе шаттай зохион байгуулж тодорхой мэдээллээр хангав.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2014 оны А/52 дугаар тушаалаар аймгийн Засаг даргын Тамгын газарт “Хайрцгаар санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам”-ыг батлуулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцгийг ажиллуулж энэ онд 15 санал хүсэлт ирснийг бүртгэж, 1 өргөдлийг бүртгэн холбогдох албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр уламжилж түлшний хөнгөлөлтөд хамруулж, 3 санал хүсэлтийг дугтуйны хаягаар шилжүүлж, 9 буцах хаяггүй санал хүсэлт, 2 талархал ирснийг холбогдох албан тушаалтанд танилцуулж ажиллав.

Аймгийн Засаг даргаас бусад байгууллага, албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн 166 өргөдлийн шийдвэрлэлтийн хариуг албан бичгээр хүлээн авч, шийдвэрлэлтийг хуулийн хугацаанд хяналт тавьж ажиллав.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, хэлтсийн дарга нарын иргэд хүлээж авах цагийн хуваарийг шинэчлэн батлуулан мөрдөн ажиллаж, аймгийн Засаг дарга хуваарийн дагуу 25 удаагийн Пүрэв гарагийн иргэд хүлээн авч уулзах уулзалтаар 414 иргэний амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч хариу өгч шийдвэрлэв.


Аймгийн Засаг дарга амаар биечлэн гаргасан 8 саналыг 11 байгууллагад албан бичгээр уламжлан хүргүүллээ. Хайрцгаар ирүүлсэн 1 иргэний санал хүсэлтийг Сууц өмчлөгчдийн холбоодод хүргүүлж хариу авлаа.

Аймгийн Засаг даргын хүлээн авсан амаар биечлэн гаргасан өргөдөл, гомдлыг авч үзвэл: талархал 10, ажил хүссэн 92, гэр хүссэн 14, тусламж хүссэн 24, шинээр баригдаж байгаа захаас павильон 28, газрын асуудлаар 34, санал 15, халаалтын асуудлаар 5, түлшний хөнгөлөлтөнд орохыг хүссэн 3, бусад 189 иргэн хүлээн авч асуудлыг шийдвэрлэсэн байна.

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд аймгийн Засаг дарга 83 иргэнд 9.040.000 төгрөгийн буцалтгүй тусламж олголоо. Нийгмийн халамжийн тухай Монгол улсын хуулийн дагуу 21 иргэнд гэр авахад нь дэмжлэг үзүүлж нийт 25.200.000 төгрөгийн тусламж, гэр нь шатсан 2 иргэнд Засаг даргын захирамжаар тус бүр 1800000 төгрөгийн үнэ бүхий гэр олголоо.

Хөдөлмөрийн чадвараа 50 хувь алдсан, асран хамгаалах хүнгүй, гэр оронгүй нэг иргэнийг аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн төв дэх “Баруун бүсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нөхөн сэргээх төв”-ийн асрамжийн үйлчилгээнд хамрууллаа.

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлэх тухай” хуулийн хүрээнд 17 сумын 116 байгууллага, 91 баг, аймгийн төвийн 38 төсөвт байгууллагаас өргөдөл гомдлын мэдээг нэгтгэхэд нийт 19983 өргөдөл гомдол хүлээн авснаас амаар 2516, бичгээр 16078, 11-11 төвөөр 43, цахим хэлбэрээр 27, утсаар 1319 өргөдөл, гомдол хүлээн авч, 18903 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, 531 өргөдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр шилжүүлж, 549 өргөдлийн шийдвэрлэлтийн хугацаа хүлээгдэж байна. Үүнийг графикаар үзүүлбэл:



Иргэдээс ирүүлсэн өргөдлийн 97.3 хувь болох 19434 өргөдлийг судлан шийдвэрлэж хариу өглөө. "Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1."Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтын дагуу амаар биечлэн өргөдөл, гомдлыг бүртгэх дэвтэр хэвлүүлэн хөтөлж, бүртгэж хэвшлээ.

2."Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" Монгол улсын хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх

заалтын дагуу өргөдөл гомдлыг шийдвэрлэх хугацаа сунгах тухай маягтыг шинээр гаргалаа.

3. Хайрцагар санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журам боловсруулав.

4. Санал хүсэлтийн 2 хайрцаг ажиллууллаа.

5. Санал хүсэлтийн хайрцагнаас гарсан саналыг хүлээн авах маягт, бүртгэх дэвтэр нээсэн зэрэг ажлуудыг шинээр санаачлан зохион байгууллаа.

Иргэдийн санал хүсэлт хүлээн авах 7043-1111 төвийн үйл ажиллагаа:

7043-1111 төв нь иргэдийн санал хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархал, өргөдөл нэг бүрийг мэдээллийн 5 сувгаар хүлээн авч холбогдох байгууллагад нь шилжүүлэн, шуурхай шийдвэрлэх, шийдвэрлэсэн талаархи мэдээллийг эргэж мэдээлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, иргэдийн санаа бодлыг төр захиргааны үйл ажиллагаанд тусгаж, төр захиргааны байгууллага болон иргэдийн хоорондын харилцааг шуурхай болгоход чиглүүлэн ажиллав.

Тус төвд ирсэн 1536 санал хүсэлт хүлээн авснаас 179 шүүмжлэл, санал хүсэлт 143, талархал 21, гомдол 1193 тус тус хүлээн авч холбогдох байгууллагад шилжүүлэн, нийт 1536 санал хүсэлт ирсэнээс 19 санал хүсэлт шийдвэрлэгдээгүй, 1517 санал хүсэлт /талархал -21/ шийдвэрлэгдэж 98.7 хувийн биелэлттэй байна.

Нийт хүлээн авсан 1536 санал хүсэлтийн 1305 дуудлагаар, 204 биечлэн, 12 вэб сайтаар, 13 фэйс бүүкээр, 2 и-мэйлээр тус тус хүлээн авсан байна.

2014 онд ирүүлсэн санал хүсэлтийг багцлан авч үзвэл халаалт дулааны чиглэлээр 122, боловсролын салбарын талаар 190, хууль эрх зүйн талаар 93, эрүүл мэндийн чиглэлээр 88, орчин, орчны эрүүл ахуйн талаар 177, агаарын бохирдол 35, газар өмчлөлтэй холбоотой асуудлаар 69, бусад асуудлаар 762 санал хүсэлт тус тус ирүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газарт Засгийн газрын 1111 төвд ирүүлсэн 5 удаагийн 32 иргэний санал, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн, хариуг хугацаанд нь хүргүүллээ.

Тайлант онд төрийн үйлчилгээний цахим машинаас /ТҮЦ/ 5482 иргэн лавлагаа авснаас төрсний бүртгэлийн лавлагаа 90, иргэний үнэмлэхний лавлагаа 3726, оршин суугаа хаягийн тодорхойлолт 419, үл хөдлөх хөрөнгийн лавлагаа 913, гэрлэлт бүртгэлтэй тухай лавлагаа 75, гэрлэлт бүртгэлгүй тухай лавлагаа 59, гэрлэлт цуцлалтын тухай лавлагаа 3, хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа 3, санал хүсэлт өргөдөл гомдол 6, иргэний үнэмлэх захиалах 185, гаалийн байгууллагад өртэй эсэх лавлагаа 2, татварын лавлагаа 1 тус тус авч үйлчлүүлсэн байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны www.khovd.gov.mn цахим хуудсыг 92 хуудас бүхий 780 гаруй шинэ мэдээ, мэдээлэл, ярилцлага, сурвалжлагаар цаг тухайд нь баяжуулж, давхардсан тоогоор 67254 гаруй хэрэглэгч хандсан тооцоо байна.

Засаг даргын зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүд, байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн үндсэн дөрвөн чиглэлээр мэдээллийг цахим хуудсанд дэлгэрэнгүй оруулж тухай бүрд нь баяжуулан тогтмолжуулснаас гадна “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвөөр төрийн ямар үйлчилгээ үзүүлдэг, эрх зүйн зохицуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллүүдийг нэмж байршуулав.

Цахим ертөнцөд хамгийн их хэрэглэгчтэй www.facebook.com дэх “Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар” гэсэн нэртэй хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, зарыг шуурхай байршуулан хэвшиж 2080 гишүүнчлэлтэй боллоо.

ТӨРИЙН ЗАХИРГАА УДИРДЛАГЫН
ХЭЛТЭС